MAGIC
CONSULTING AUDIT

АУДИТ
БАТАЛГААЖУУЛАХ
ҮЙЛЧИЛГЭЭ

ЗААН ИНВЕСТ ББСБ ХХК-ИЙН
2022 ОНЫ 12 САРЫН 31-ЭЭР
ТАСАЛБАР БОЛГОСОН



АУДИТОРЫН ТАЙЛАН

АГУУЛГА 1

УДИРДЛАГЫН ХАРИУЦЛАГЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ 2
ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН 3

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН 5
ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН 6
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН 7
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН 8

ТОДРУУЛГА 1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	9
ТОДРУУЛГА 2	Харилцагчдад олгосон зээл	9
ТОДРУУЛГА 3	Татвар, НДШ-ийн авлага	9
ТОДРУУЛГА 4	Бусад авлага	10
ТОДРУУЛГА 5	Бусад хөрөнгө	10
ТОДРУУЛГА 6	Үндсэн хөрөнгө	10
ТОДРУУЛГА 7	Бусад өр төлбөр	10
ТОДРУУЛГА 8	Дүрмийн сан	10
ТОДРУУЛГА 9	Хүү болон түүнтэй адилтгах орлого	10
ТОДРУУЛГА 10	Хүүгийн бус зардал	11
ТОДРУУЛГА 11	Орлогын албан татварын зардал	11
ТОДРУУЛГА 12	Хүлээж болзошгүй үүрэг хариуцлага	11
ТОДРУУЛГА 13	Тайлангийн дараах үйл явдал	11

2022 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон
Санхүүгийн тайлан бэлтгэх болон батлах
Удирдлагын хариуцлагын мэдэгдэл

Энэхүү мэдэгдэл нь "ЗААН ИНВЕСТ ББСБ"Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн ("Компани" гэх) 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага болон аудиторын хариуцлагыг ялгахад чиглэгдсэн болно.

Удирдлага нь Компанийн санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт(СТОУС)-уудын дагуу үнэ зөв бэлтгэх үүрэгтэй бөгөөд эдгээр санхүүгийн тайлангууд нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант хугацааны санхүүгийн гүйцэтгэл, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийг СТОУС, Монгол Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хууль, холбогдох заавар журамд нийцүүлэн үнэн зөв, шударгаар илэрхийлсэн байх ёстой.

Санхүүгийн тайланг бэлтгэхэд удирдлага дараах хариуцлагыг хүлээдэг.
Үүнд:

- Компанийн үйл ажиллагааны онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгож, тууштай мөрдөх
- Ул үндэслэлтэй, хянамгай шийдвэр гаргах болон тооцоолол хийх
- СТОУС-ыг дагаж мөрдсөн эсэхээ дурдаж, хэрэв материаллаг зөрүү буюу өөрчлөлт байгаа бол түүнийг санхүүгийн тайланд тодруулж, тайлбарлах
- Компани ирээдүйд бизнесээ үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөл нь тохиромжгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайланг тасралтгүй үйл ажиллагаагаа явуулах төсөөлөлд үндэслэж бэлтгэх

Удирдлага нь мөн түүнчлэн,

- Дотоод хяналтын үр дүнтэй, тууштай систем боловсруулж, хэрэгжүүлж, ажиллуулах
- Компанийн санхүүгийн байдлыг үнэн зөвөөр, аливаа хугацаанд харуулахуйц нягтлан бодох бүртгэл хөтлөх ажиллагааг зохион байгуулах
- Компанийн нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэхүйцээр зохион байгуулагдсан байх
- Хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- Заль мэхний асуудал, алдаа болон бусад зөрчлийг илрүүлэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх зэрэг үүрэг хүлээдэг.

Бид эдгээр үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт, Монгол Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмын дагуу үнэ зөв бэлтгэсэн гэдгээ баталж байна.

_____ _____

Захирал Л.Нэргүй Ерөнхий Нягтлан Бодогч

Огноо: 2023/01/12

МЭЖИК КОНСАЛТИНГ АУДИТ ХХК
Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
25-р хороо, Манлай Баатар Дамдинсүрэнгийн
гудамж, UB tower, 15 давхар, 1502 тоот.
Утас: 7013-1044. И-мэйл: info@magicgroup.mn
Вэб хуудас: www.magicgroup.mn

2023-02-10 дугаар 23-ИВ/04/06

танай _____ -ны дугаар _____-т

ЗААН ИНВЕСТ ББСБ ХХК-ийн
хувьцаа эзэмшигчид

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Дүгнэлт

Бид **ЗААН ИНВЕСТ ББСБ ХХК** ('Компани' гэх)-ийн 2022 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр тасалбар болгосон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогуудын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар Компанийн 2022 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-уудын дагуу үнэн зөв толилуулж байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Нягтлан бодогчдын Ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЁЗОУСЗ)- өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу компаниас хараат бус бөгөөд хууль болон НБЁЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

Бусад мэдээлэл

Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг. Бидний санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй ба бид уг мэдээлэлд аливаа баталгаа илэрхийлээгүй. Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ. Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж үзвэл энэ байдлыг компанийн засаглал хариуцсан этгээдэд мэдэгдэх ёстой. Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудал нь тайлант жилийн санхүүгийн тайланд аудитад хамгийн ихээр нөлөө үзүүлэхүйц зүйлс юм. Бидний гаргасан тайланд томоохон хэмжээний аудитын гол асуудал гараагүй гэж тодорхойлж байна.

Тасралтгүй байдалтай холбоотой материаллаг тодорхойгүй байдал

Тасралтгүй үйл ажиллагааны зарчимтай холбоотой материаллаг тодорхой бус байдал бидэнд ажиглагдаагүй.

ЗААН ИНВЕСТ ББСБ ХХК-ийн 2022 оны 12 сарын 31-ний өдрөөрх 03-ив/04/06 тоот Хараат бус аудиторын тайлангийн (үргэлжлэл)

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн тайлангийн талаар хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь СТОУС-уудын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр аргагүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах Компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ. Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлага хүлээдэг.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилангаас эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үзнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээсэн үүрэг хариуцлагын тодорхойлолтыг Мэжик Консалтинг Аудит ХХК-ийн http://www.magicgroup.mn/mn/uureg вэб сайтад байршуулсан. Уг тодорхойлолт нь аудиторын тайлангийн нэг хэсэг юм.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль" -ийн 94-р зүйлд заасан хуулийн этгээд болох **ЗААН ИНВЕСТ ББСБ ХХК**-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

МЭЖИК КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

УЛААНБААТАР ХОТ

С.Мөнхбаяр
Мэргэшсэн нягтлан бодогч, Партнер
Мэжик Консалтинг Аудит ХХК

Улаанбаатар хот, Монгол Улс
2023 оны 02 дугаар сарын 10

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Тодруулга	2021.12.31	2022.12.31
ХӨРӨНГӨ			
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ			
Мөнгөн хөрөнгө	1	7,620,234	14,056,518
Зээл /цэврээр/	2	2,718,792,988	3,011,950,622
Татвар, НДШ-ийн авлага	3	52,843,768	45,361,124
Бусад авлага	4	105,401,771	32,910,462
Бусад хөрөнгө	5	254,693,000	269,340,000
Эргэлтийн хөрөнгийн нийт дүн		**3,139,351,761**	**3,373,618,726**
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ			
Үндсэн хөрөнгө	6	1,291,367	240,448,406
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		**1,291,367**	**240,448,406**
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		**3,140,643,128**	**3,614,067,132**
ӨР ТӨЛБӨР			
Богино хугацаат өр төлбөр			
ХАОАТ-ын өглөг	7	-	660,542
Орлогын албан татварын өглөг	7	34,788,510	16,789,770
Бусад	7	20,048	2,888
Богино хугацаат өр төлбөрийн дүн		**34,808,558**	**17,453,200**
Нийт өр төлбөрийн дүн		**34,808,558**	**17,453,200**
ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ			
Энгийн хувьцаа	8	2,500,000,000	2,500,000,000
Хуримтлагдсан ашиг /алдагдал/		605,834,570	1,096,613,932
Эзэмшигчдийн өмчийн дүн		**3,105,834,570**	**3,596,613,932**
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН		**3,140,643,128**	**3,614,067,132**
		-	-

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Тодруулга	2021.12.31	2022.12.31
Хүүгийн орлого	9	**644,490,934**	**712,446,726**
Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого		639,635,781	709,121,846
Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого		4,855,153	3,324,880
Хүүгийн бус орлого		**2,115,500**	**8,869,046**
Хүүгийн бус зардал	10	**49,200,969**	**55,201,676**
ЦЭВЭР ХҮҮГИЙН БУС ОРЛОГО/ЗАРДЛЫН ДҮН		**(47,085,469)**	**(46,332,630)**
Зээлийн эрсдэлийн зардал		(10,252,484)	(170,377,366)
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ/АЛДАГДАЛ		**587,152,982**	**495,736,730**
Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал		**587,152,982**	**495,736,730**
Орлогын татварын зардал	11	5,871,530	4,957,367
ЦЭВЭР АШИГ		**581,281,452**	**490,779,363**

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Хувьцаат капитал	Халаасны хувьцаа	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2021 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	**2,500,000,000**	**-**	**605,834,570**	**3,105,834,570**
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	**-**
Залруулсан үлдэгдэл	**2,500,000,000**	**-**	**605,834,570**	**3,105,834,570**
Тайлант үеийн цэвэр ашиг:	-	-	490,779,363	490,779,363
2022 оны 12 сарын 31-р үлдэгдэл	**2,500,000,000**	**-**	**1,096,613,932**	**3,596,613,932**

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	**(1,298,388,089)**	**6,436,284**
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	**3,899,435,231**	**4,553,703,332**
Зээлийн хүүгийн орлого	562,419,252	784,920,971
Гадаад валютын ханшийн зөрүү	-	3,229,457
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	2,115,500	2,685,000
Бусдад олгосон зээлийн буцаан төлөлт	3,001,988,740	3,448,264,904
Бусад олгосон мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	332,911,739	314,603,000
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	**5,197,823,320**	**4,547,267,048**
Үндсэн ба нэмэгдэл цалин	20,687,422	20,827,877
Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын зардал	6,462,651	6,225,198
Албан томилолт, сургалтын зардал	455,000	-
Шатахуун, холбоо, интернет, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	1,290,593	1,853,829
Бичиг хэргийн зардал, ариун цэврийн зардал	567,330	126,300
Татвар, даатгалын төлсөн мөнгө	29,221,514	16,195,645
Зар сурталчилгаанд төлсөн мөнгө	1,442,000	240,000
Зээл болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбогдон гарсан зардал	73,000	280,000
Аудитын төлбөр, мэргэжлийн зөвлөгөө үйлчилгээний мөнгө	887,266	6,253,549
Зохицуулалтын үйлчилгээний хураамжид төлсөн мөнгө	3,000,000	2,700,000
Бусад үйлчилгээнд төлсөн мөнгө	172,080	529,100
Бусдад олгосон зээл	4,539,150,000	3,911,800,000
Програм хангамжид төлсөн	4,009,500	4,524,550
Түрээсийн зардалд төлсөн	5,616,000	5,616,000
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	235,000,000
Бусдад олгосон мөнгөн урьчилгаа	584,788,964	335,095,000
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	**(600,000)**	**-**
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн орлого	**-**	**-**
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн зарлага	**600,000**	**-**
Бусад	600,000	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	**(1,298,988,089)**	**6,436,284**
МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	**1,306,608,323**	**7,620,234**
МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	**7,620,234**	**14,056,518**

1 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Касс дахь бэлэн мөнгө	2,026,869	1,341,354
Банкин дахь мөнгөн хөрөнгө	5,593,365	12,715,164
	7,620,234	**14,056,518**

2022-12-31-ны өдрийн байдлаар мөнгөн хөрөнгийн 9.54 хувийг касс дахь мөнгөн хөрөнгө эзэлж байна. Мөн нийт хөрөнгийн 0.39 хувийг мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө эзэлж байна.

2 Харилцагчдад олгосон зээл

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Харилцагчдад олгосон зээл	2,729,045,472	3,192,580,472
Нийт зээл /цэврээр/	2,718,792,988	3,011,950,622
Зээлийн эрсдлийн сан	**10,252,484**	**180,629,850**

Зээлийн ангилал

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Хэвийн зээл	2,677,242,656	2,579,292,520
Хугацаа хэтэрсэн зээл	13,491,101	211,874,979
Хэвийн бус зээл	38,311,715	199,304,973
Эргэлзээтэй зээл	-	163,796,286
Муу зээл	-	38,311,714
	2,729,045,472	**3,192,580,472**

2022-12-31-ны байдлаар нийт зээлийг 85.64 хувийг хэвийн зээл эзэлж байна. Нийт хөрөнгийн 83.34 хувийг эзэлж байна.

Зээлийн ангилал		
Хувийн сектор	390,273,556	1,396,884,015
Иргэд	2,338,771,916	1,795,696,457
	2,729,045,472	**3,192,580,472**

Банк Бус Санхүүгийн Үйл Ажиллагааны Тухай хуулийн 13 дугаар зүйл 13.1-д "Банк бус санхүүгийн байгууллагаас нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгох зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүн нь тухайн банк бус санхүүгийн байгууллагын өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтэрч болохгүй" гэж заасныг зөрчөөгүй байна.

3 Татвар, НДШ-ийн авлага

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Татварын авлага	52,843,768.00	45,361,124.00
	52,843,768.00	**45,361,124.00**

4 Бусад авлага

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн авлага	105,401,771	32,910,462
	105,401,771	**32,910,462**

Компани гэрээний хүүгийн авлагыг хуримтлуулж тооцоолон бүртгэж байна.

5 Бусад хөрөнгө

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Урьдчилж төлсөн тооцоо	77,073,000	50,000,000
Дараа тооцоо	177,620,000	219,340,000
	254,693,000	**269,340,000**

6 Үндсэн хөрөнгө

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Эд хогшил	-	5,845,000
Хуримтлагдсан элэгдэл /эд хогшил/	-	(508,266)
Техник хэрэгсэл	2,769,500	2,769,500
Хуримтлагдсан элэгдэл /техник хэрэгсэл/	(1,478,133)	(2,657,828)
Дуусаагүй барилга	-	235,000,000
	1,291,367	**240,448,406**

7 Бусад өр төлбөр

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
ХХОАТ-ын өглөг	-	660,542
Орлогын албан татварын өглөг	34,788,510	16,789,770
Бусад	20,048	2,888
	34,808,558	**17,453,200**

8 Дүрмийн сан

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Дүрмийн сан	2,500,000,000	2,500,000,000
Хувьцаа /ширхэг/	2,500,000	2,500,000

"Заан Инвест ББСБ" ХХК 2,500,000,000 төгрөгийн хувьцаат капитал нь нэг бүр нь 1,000 төгрөгийн үнэтэй 2,500,000 ширхэг хувьцаанаас бүрдэж байна.

9 Хүү болон түүнтэй адилтгах орлого

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	639,635,781	709,121,846
Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого	4,855,153	3,324,880
	644,490,934	**712,446,726**

10 Хүүгийн бус зардал

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зардал	-	2,954,589.00
Үндсэн болон нэмэгдэл цалин	25,927,711	25,938,326
Нийгмийн даатгалын зардал	3,360,964	3,242,291
Сургалтын зардал	455,000	-
Аудитын төлбөр, мэргэжлийн үйлчилгээ	1,512,266	5,688,731
Түрээс	5,616,000	5,616,000
Үндсэн хөрөнгийн элэгдэл	1,272,325	1,687,960
Харилцаа холбоо, интернет	799,595	1,923,629
Сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээ	175,100	30,200
Зохицуулалтын хураамжийн зардал	3,000,000	2,700,000
Автоматжуулалттай холбоотой урсгал зардал	4,317,398	4,562,550
Зар сурталчилгаа, маркетингийн судалгаа	2,342,000	240,000
Бичиг хэргийн зардал	346,430	126,300
Бусад	76,180	491,100
	49,200,969	**55,201,676**

Компани нь өдөр тутмын үйл ажиллагаа явуулахын тулд хүүгийн бус зардлуудыг гаргадаг 2022-12-31-ны байдлаар хүүгийн бус зардлын 46.99 хувийг цалингийн зардал эзэлж байна.

11 Орлогын албан татварын зардал

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Тайлант үеийн орлогын албан татварын зардал	5,871,530	4,957,367
	5,871,530	**4,957,367**

12 Хүлээж болзошгүй үүрэг хариуцлага

Шүүхийн нэхэмжлэх

2022 оны 12 сарын 31-ний байдлаар ЗААН ИНВЕСТ ББСБ ХХК нь шийдвэрлээгүй шүүхийн нэхэмжлэлгүй байна.

13 Тайлангийн дараах үйл явдал

2023 оны 01 сарын 01-нээс 2023 оны 02 сарын 10-ны өдөр хүртэл ЗААН ИНВЕСТ ББСБ ХХК-ийн санхүүгийн тайлангуудад нөлөөлөхүйц, тодруулахыг шаарддаг үйл явдал гараагүй байна.

Аудитор _____ Н.Мөнхзаяа /Мэргэшсэн нягтлан бодогч/

Туслах аудитор_____ Б.Данзандорж /Бүртгэл санхүүгийн мэргэжилтэн/

2023 оны 02 сарын 10

ҮНДЭСНИЙ АУДИТЫН КОМПАНИ

Since 2007



МЭЖИК КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 25-р хороо, UB Tower, 15-р давхар, 1502 тоот

Утас: 7013-1044 **Цахим хуудас:** www.magicgroup.mn **Э-шуудан:** audit@magicgroup.mn